



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/179

Ховд

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Рашаант багийн 17 дугаар гудамжны 25 тоотод байрлах Раднаагийн Сайханжаргал /ПЭ76072612/-ын эзэмшлийн худалдаа, үйлчилгээний зориулалттай 38 метр квадрат газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилийн хугацаагаар,

2.Жаргалант сумын Магсаржав багийн нутаг дэвсгэр 3 дугаар 60 айлын орон сууцны хойд талд байрлах Цагааны Гиймаа /ПЮ50092005/-ийн эзэмшлийн авто гражны зориулалттай 29 метр квадрат газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 5 жилийн хугацаагаар тус тус сунгасугай.

3. Газар эзэмших эрх нь сунгагдсан иргэнтэй гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

